



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/14

Номгон

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө,
авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг
2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 7.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г нэгдүгээр хавсралтаар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.


3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601220029





Аймгийн Засаг даргын *А.М.М.* оны *01* дүгээр сарын *07*-ны
 өдрийн *АХ/14* дугаар захирамжийн *1*-р хавсралт




АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4	5
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх үйл	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube сувар), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;	Жилийн турш	Сум, байгууллагууд
		1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	Жилийн турш	Сум, байгууллагууд
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Жилийн турш	Сум, байгууллагууд
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдаа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх;	1 дүгээр улиралд	Хууль, эрх зүйн хэлтэс
		2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	Жилийн турш	Сум, байгууллагууд
		2.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтэс, сургагч багш

1	2	3	4	5
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, 3.2.Мөрдөгчийн мэдэгдэл, 3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ;	Жилийн турш	Сум, байгууллагууд
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Жилийн турш	Сум, байгууллагууд
		4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	Жилийн турш	Сум, байгууллагууд
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Жилийн турш	Сум, байгууллагууд
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;	Жилийн турш	Сум, байгууллагууд
		Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4	Жилийн турш	Сум, байгууллагууд
		Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах	Жилийн турш	Сум, байгууллагууд
		Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг үнэн зөв тайлагнан хагас жилд /6 дугаар сарын 10/, жилийн эцэст /12 дугаар сарын 10-ны дотор/ ирүүлэх	Жилийн турш	Сум, байгууллагууд

Аймгийн Засаг дарга  онь  дүгээр сарын 07-ны өдрийн  дүгээр захирамжийн -р хавсралт



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийх ажлын агуулга	Шалгуур үзүүлэлт			Хариуцах хэлтэс, алба, байгууллага,
		Хөрөнгө санхүү	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	
1	2	3	4	5	6
<p align="center">ЗОРИЛТ Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</p>					
1.1.	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Шаардахгүй	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох /цахим хуудсанд байршуулах/	Жилийн турш	Төрийн албаны салбар зөвлөлийн Баянхонгор дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Хүний нөөц, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
1.2.	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Шаардахгүй	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Жилийн турш	

1	2	3	4	5	6
1.3.	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	Байгууллагын төсөв	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Жилийн турш	Төрийн албаны салбар зөвлөлийн Баянхонгор дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
1.5	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Байгууллагын төсөв	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	Жилийн турш	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Мэдээлэл технологийн мэргэжилтэн
			Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах	Жилийн турш	
1.6	Нийтийн албаны сургалтны институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Байгууллагын төсөв	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	Жилийн турш	Хууль эрх зүйн хэлтсийн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
ЗОРИЛТ Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх					
2.1.	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Байгууллагын төсөв	Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Жилийн турш	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Мэдээлэл технологийн мэргэжилтэн

1	2	3	4	5	6
2.2.	Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	Шаардахгүй	Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	Жилийн турш	Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн мэргэжилтэн, Санхүү төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн
2.3.	Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	Шаардахгүй	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	Жилийн турш	Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэг
2.4.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Шаардахгүй	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	Жилийн турш	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Хүний нөөц, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
ЗОРИЛТ Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх					

1	2	3	4	5	6
3.1.	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	Байгууллагын төсөв	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Жилийн турш	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлтийн мэргэжилтэн, Хүнс, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн
		Шаардахгүй	Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх	Жилийн турш	
3.2.	4.1.3.4.төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах.	Шаардахгүй	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх	Жилийн турш	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлтийн мэргэжилтэн, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Төсвийн мэргэжилтэн
3.3.	Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	Шаардахгүй	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Жилийн турш	Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч,
ЗОРИЛТ Дөрөв. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх					
4.1.	Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарла-	Шаардахгүй	Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж	Жилийн турш	

1	2	3	4	5	6
	сан эрх зүйн орчинг сайжруулах		хэрэгжүүлэх		
ЗОРИЛТ Тав. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих					
5.1.	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	Шаардахгүй	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Жилийн турш	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Мэдээлэл технологийн мэргэжилтэн
		Шаардахгүй	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	Жилийн турш	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хүнс, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн
ЗОРИЛТ Зургаа. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх					
6.1.	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	1.500.000 мян/төг	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
6.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион	500.000 мян/төг	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх	Жилийн турш	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Сургалт сурталчилгаа

1	2	3	4	5	6
	байгуулах				хариуцсан мэргэжилтэн, сургагч багш

oOo